

ГАРЧИГ

НЭГ. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА.....	2
ХОЁР. СӨРӨГ НӨЛӨӨЛЛӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ, БУУРУУЛАХ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ	6
ГУРАВ. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ	8
ДӨРӨВ. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	10
ТАВ. БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ	12
ЗУРГАА. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ ТӨЛӨВЛӨГӨӨ	12
ДОЛОО. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭ	13
НАЙМ. ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	14
ЕС. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	18
АРАВ. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР.....	22
АРВАН НЭГ. УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ.....	25
АРВАН ХОЁР. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ НӨЛӨӨЛӨЛД ӨРТӨГЧ ОРШИН СУУГЧИД, ОРОЛЦОГЧ ТАЛУУДАД ТАЙЛАГНАХ ХУВААРЬ.....	26
ТАВ. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН 2024 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ НЭГДСЭН ТӨСӨВ.....	27

НЭГ. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Төсөл хэрэгжүүлэгч аж ахуйн нэгж, байгууллагын нэр, хаяг

Төсөл хэрэгжүүлэгч байгууллага: “Ам Та Тү” ХХК

Регистрийн дугаар: 2633086


Улсын бүртгэлийн дугаар: 711002059

Дорнод аймаг, Хэрлэн сум 10-р баг /Хэрлэн/, 27-р байр, 49-18 тоот. Утас: 99070953

Төслийн байршил:

Аралт худаг нэртэй шохойн чулууны орд нь засаг захиргаа харъяаллын хувьд Дорнод аймгийн Чойбалсан сумын нутагт, Чойбалсан хотоос зүүн хойш 71 км, Чойбалсан сумаас хойд зүгт 21 км зайд оршино. Аралт худагийн MV-004136 тусгай зөвшөөрөлтэй талбайн солбицол

Тусгай зөвшөөрөл №	Олгогдсон (он-сар-өдөр)	Хугацаа (жил)	Цэгийн дугаар	Уртраг (град, мин, сек)	Өргөрөг (град, мин, сек)
MV-004136 (26.85 га)	2007-02-12	30	1	114° 48' 4.29"	48° 40' 3.96"
			2	114° 47' 39.3"	48° 40' 3.96"
			3	114° 47' 39.3"	48° 40' 20.97"
			4	114° 48' 4.29"	48° 40' 20.97"



Зураг 1. Аралт худгийн MV-004136 тоот тусгай зөвшөөрөлтэй талбайн байрлал

Төслийн хүчин чадал

Дорнод аймгийн Чойбалсан сумын нутагт орших MV-004136 тоот тусгай зөвшөөрөлтэй Аралт худаг нэртэй шохойн чулууны 26.85га талбайтай ордыг “Ам Та Тү” ХХК эзэмшдэг.

“Ляпислязурь эрдэнэ” ХХК 2018 онд “Аралт худгийн шохойн чулууны ордыг ил аргаар ашиглах техник эдийн засгийн үндэслэл”-ийг боловсруулж, Эрдэс Баялгийн Мэргэжлийн Зөвлөлийн 2018 оны 08 сарын 30-ны өдрийн Т/18-12-04 дугаартай дүгнэлт, Ашигт Малтмал, Газрын тосны Газрын 2018 оны 10 сарын 04-ны өдрийн Т/135 дугаартай тушаалаар баталгаажуулсан байна.

“Ам Та Тү” ХХК нь өөрийн эзэмшлийн ордыг түшиглэн шохой үйлдвэрлэж, Дорнод аймгийн Дашбалбар сумын нутагт үйл ажиллагаа явуулдаг “Шинь шинь” ХХК-ийн уулын баяжуулах үйлдвэр, тус аймгийн Цагаан-Овоо сумын нутагт “Степ голд” ХХК-ийн хэрэгжүүлж буй Алтан цагаан овоо төсөлд нийлүүлж байна.

Ил уурхай

Ордын нөөц:

Тус ордод хийсэн хайгуулын ажлын үр дүнгийн тайланг 1976 оны 12-р сарын 29-ний өдөр БНМАУ-ын ГУУҮЯ-ны ШУТЗ-ийн хурлаар авч хэлэлцсэн №79 тоот дүгнэлтээр ордын нөөцийг бодитой (В=748.5 мян.тн) болон боломжтой (С=1159.9 мян.тн) зэргээр В+С1=1908. мян.тн-оор улсын нөөцийн нэгдсэн санд бүртгүүлсэн байдаг.

Уурхайн хүчин чадал:

Аралт худгийн шохойн чулууны ил уурхайгаас 30.0 мян.тн шохойн чулуу олборлож, дундаж шохой гаралт 21.49 мян.тн байхаар жилийн хүчин чадлын төлөвлөсөн. Энэ хүчин чадлаар олборлоход ордын нөөц нь 63.1 жил хүрэлцээтэй. Ил уурхайн ажиллах горим нь манай орны улирлын шинж чанар, цаг агаар, уур амьсгал, уурхайн үндсэн техник тоног төхөөрөмжийн бүтээл, жилийн хүчин чадал зэргээс ихээхэн шалтгаална.

Ил уурхайн үндсэн хэмжээс: Уурхайн ёроолын түвшин 775м, ажлын доголын өндөр хөрс хуулалтад 5м, шохойн чулууны олборлолт 5м, доголын налуу 550, ажлын талбайн өргөн 20м, авто замын налуу 80% байна.

Ашиглалтын систем: Ордыг ил уурхайн аргаар ашиглах ба чулуулгийг өрөмдлөг тэсэлгээний ажлын тусламжтайгаар сийрэгжүүлэлтийн ажлыг хийсний дараагаар экскаватор авто самосвалын хослолоор ухаж, ачих ажлыг гүйцэтгэн хөрсийг гадаад овоолгод байршуулж шохойн чулуу шатаан боловсруулах үйлдвэрийн дэргэдэх шохойн чулууны овоолгод тээвэрлэн овоолно.

Ил уурхайг нээх: Ордыг нээх уулын ажлыг ордын үрд хэсгээс буюу хайгуулын шугам III-III-ийн дагууд ил гарштай хэсгээс 805 м-ийн өндөржилтийн цэгээс траншей нэвтэрч шохойн чулууны нөөц бэлтгэн ашиглалтын ажлыг эхэлнэ.

Шимт хөрс хуулалт: Үржил шимт хөрсийг хуулахдаа 0.3м-ээс ихгүй зузаантайгаар утгуурт ачигчаар хуулна. Үржил шимт хөрсийг техникийн болон биологийн нөхөн сэргээлт хийх үед ашиглах зорилгоор ил уурхайн олборлолтын талбайгаас гадна талд үржил шимт хөрсний овоолгыг 2 м хүртлэх өндөртэйгээр хийж үржил шимт хөрсийг хадгалах, арчлах, тээвэрлэлтийн стандартыг мөрдөж ажиллана.

Хөрс хуулалтын ажил: Ил уурхайн хөрсийг өрөмдлөг, тэсэлгээний аргаар сийрэгжүүлэн хуулна. Хөрс хуулалтын ажилд 1м³-ын утгуурын багтаамжтай Солонгос улсад үйлдвэрлэсэн HYUNDAI R210LC-7 маркийн гидравлик экскаватор болон 20тн даацтай HOWO маркийн БНХАУ-д үйлдвэрлэсэн автосамосвалыг тус тус ашиглана.

Шохойн чулуу олборлолт: Шохойн чулуу олборлолтын ажлыг экскаватор автосамосвалын хослолоор ухаж ачин, тээвэрлэж шохойн чулуу шатаан боловсруулах үйлдвэрийн дэргэд байрлах шохойн чулууны түр овоолгод овоолно. Хүдэр олборлолтын ажилд 1м³-ын утгуурын багтаамжтай Солонгос улсад үйлдвэрлэсэн HYUNDAI R210LC-7 маркийн гидравлик экскаватор болон 20 тн даацтай HOWO

маркийн БНХАУ-д үйлдвэрлэсэн автосамосвалыг тус тус ашиглана. Уурхайн хөрс хуулалт болон шохойн чулуу олборлолтын тээвэрлэлтэнд 2 ширхэг автосамосвал хүрэлцээтэй гэж тооцсон байна.

Хүснэгт 1. Ил уурхайн уулын ажлын календарчилсан төлөвлөгөө

№	Ашиглалтын жилүүд	Уулын цул			Шохойн чулуу		Хөрс хуулалт	
		мян.м ³	мян.м ³	мян.тн	мян.м ³	м ³ /тн	м ³ /м ³	
1	I жил	8.30	6.15	15.25	2.15	0.14	0.35	
2	II жил	12.314	10.28	25.5	2.03	0.08	0.20	
3	III жил	14.24	12.10	30	2.14	0.07	0.18	
4	IV жил	20.303	12.10	30	8.21	0.27	0.68	
5	V жил	21.22	12.10	30	9.12	0.30	0.75	
6	VI жил	19.326	12.10	30	7.2	0.24	0.60	
7	VII жил	21.4	12.10	30	9.3	0.31	0.77	
8	VIII жил	22.4	12.10	30	10.3	0.34	0.85	
9	IX жил	22.6	12.10	30	10.5	0.35	0.87	
10	Хжил	22.5	12.10	30	10.4	0.35	0.86	
	Дүн	184.60	113.21	280.76	71.39	0.25	0.63	

Ил уурхайн үндсэн тоног төхөөрөмжид 1м³-ийн утгуурын багтаамжтай HYUNDAI-R210LC-7 маркийн урвуу утгуурт экскаватор, 20 тонны даацтай SINOTRUK HOWO авто самосвал-2 ширхэг, 120-155мм-ийн диаметртэй JK-590 маркийн өрмийн машин, 3м³ шанаганы багтаамжтай SDLG-933 маркийн утгуурт ачигч, туслах машин механизм зэргийг ашиглана.

Өрөмдлөг, тэсэлгээ: JK590 маркийн өрмийн 1 машин 1 м цооног өрөмдөхөд 13.9м³/м хөрс хуулалт, 13.9м³/м шохой сийрэгжүүлнэ. Өрмийн машины жилд гүйцэтгэх ажлын эзлэхүүн нь 114.3мян.м³/м хөрс хуулалт, 140.78 мян.м³ шохой байна.

Ил уурхайн тэсэлгээ: Тэсэлгээгээр жилд 10.9 мян.м³ хөрс хуулалт, 12.10 мян.м³ шохойн чулуу олборлоход бэлтгэх сийрэгжүүлэх ажил жилд 1-2 удаа хийнэ. Тус ажлыг Уул Уурхай, Хүнд Үйлдвэрийн Сайдын 2017 оны 10 марын 02-ны өдрийн А/210 дугаар тушаалаар үйлдвэрлэлийн зориулалтаар тэсэлгээний ажил үйлчилгээ эрхлэх 142 дугаартай тусгай зөвшөөрөл 3 жилийн хугацаатай авсан “Монмаг” ХХК-аар гэрээгээр гүйцэтгүүлнэ

Шохойн чулуу шатаан боловсруулах үйлдвэр

Шохой боловсруулах үйлдвэр нь жилд 30000 тн/жил хүдэр хүлээн авч жилийн 4 улирал ажиллана. боловсруулах үйлдвэрийн тоног төхөөрөмжийн ашиглалт 100%-тай ажиллах үед шатаах зуухны хоногийн хүчин чадал 166.7тн байна.

Шохойн хүдэр нь 1 шатлалт хацарт бутлуураар 20-80мм болтол бутлагдаж чичиргээт шигшүүрээр дамжин бутлагдсан хүдрийн бункерт орно. Тэндээс хүдэр дамжуулагчийн бункерт хүрч нүүрс дамжуулах бункерээс ирсэн нүүрстэй холигч бункерээр дамжин 7.7:1 гэсэн харьцаатайгаар жигд холин 250 м³-ийн багтаамжтай шохойн чулуу шатаах зууханд шанагат эльватороор хүргэгдэнэ. Шатаах зууханд орсон шохойн чулууны 28-29% нь өндөр температурт шаталтын улмаас CO₂-ийн хий болох бөгөөд уг хийг сорох вентиляторт соруулан шүүж хольц багатай хий ялгаруулна. Иймээс шатаан боловсруулах үйлдвэрээс хаягдал гарахгүй. Үлдэх 71-72% нь MNS 347:2002 стандартыг хангасан 1-р зэргийн шохой болно.

Дэд бүтэц

Барилга, байгууламж: Аралт худгийн шохойн чулууны ордын барилга байгууламжийг үйлдвэрлэлийн ба ахуйн зориулалтаар тус тусад нь, уурхайн ажиллагсдын хотхоныг уурхайгаас баруун хойд зүгт 0.5

км зайд барьж байгуулахаар төлөвлөсөн байна. Уурхайн хотхонд уурхайн захиргааны байр, хоолны газар, халуун ус, ахуй үйлчилгээний байр, уурын зуух, засварын газар, авто граж, сэлбэг материалын агуулах зэрэг барилга байгууламжууд байх ба мөн шатах тослох материалын агуулах автомашины зогсоол зэрэг багтаж байна. Барилга байгууламж болон үйлдвэрлэлийн зориулалттай объектуудыг сэндвичин угсармал хавтан хийцтэй, сэлбэг материалын агуулах зэрэгт чингэлэг ашиглана.

Дулаан хангамж: Сэрүүний улиралд ажиллах цөөн хоногт ажиллагсдын тосгон, уурхайн захиргаа, засварын барилгыг нам даралтын бага оврын зуухаар халаана.

Усан хангамж: Сумын төвийн усан хангамжийн худгаас зөөврөөр хангана. Цаашид гүний худаг гаргахаар төлөвлөж байна.

Цахилгаан хангамж: Төслийн цахилгаан хэрэглэгч нь уурхайн хотхон, засварын газар шатахуун түгээх станц, сэлбэгийн агуулах, шохойн чулуу шатаан боловсруулах үйлдвэрийн цахилгаан хэрэглэгчид байна. Нийт цахилгаан хэрэглэгчид нь харьцангуй бага чадал суурилагдсан хүчин чадалтай учраас дизель генератор ашиглахаар төлөвлөсөн байна.

Уурхайн засварын газрын болон дэд бүтцэд цахилгаан хэрэглэгчдийг цахилгаан эрчим хүчээр хангах зорилгоор 400/230В-ын хүчдэл гаргадаг, 92кВт/115кВА хүчин чадалтай ВF-C125, шохойн чулуу шатаан боловсруулах үйлдвэрийн цахилгаан хэрэглэгчдийг 120кВт/150кВА хүчин чадалтай ВF-V165 маркийн дизель цахилгаан үүсгүүрээс 0.4кВ-ын нам хүчдэлийн цахилгаан сүлжээгээр цахилгаан эрчим хүчээр хангана.

Зам, харилцаа: Тус орд нь ойролцоох сүм суурин газруудтай ердийн орон нутгийн чанартай шороон замаар холбогдоно. Үйлдвэрийн болон уурхайн дотоод замууд нь байнгын усалгаа арчилгаатай уурхайн зориулалттай сайжруулсан шороон зам байна.

Уурхайн талбайд үүрэн холбооны сүлжээ холбогддоггүй.

Уул уурхайн эдийн засаг

Зах зээл: Бүтээгдэхүүн борлуулах үнийг өнөөгийн зах зээлийн үнэ ханшид тулгуурлан тооцсон ба 1 долларын ханшийг 2018 оны 5-6-р сарын Монгол банкны дундаж ханш болох 2400 төгрөгөөр тооцоолсон байна.

Эдийн засгийн үр өгөөж: Төслийн ТЭЗҮ-д тооцсоноор 1тн бүтээгдэхүүний бүрэн өөрийн өртөг нь 157.59 мянган төгрөг болж, ашигт ажиллагааны түвшин 15.7% байна.

Мэдрэмжийн шинжилгээний дүнгээс харахад бүтээгдэхүүний зах зээлийн үнэ төслийн үнээс 20 % буурахад төсөл үр ашиггүй болж, өнөөгийн цэвэр үнэ цэнэ тэглэх учир төсөл ашигтай байх үнийн доод хязгаар болно. Нийт 49 хүнийг ажлын байраар хангаж, 1 ажилтны сарын дундаж цалин 1097.38 мянган төгрөг болж байгаа нь орон нутгийн хувьд боломжтой юм.

Үр ашгийн үзүүлэлтүүд өндөр байгаа учраас төслийг хэрэгжүүлэх нь ашигтай хэмээн дүгнэж байна.

Төсөл хэрэгжүүлэх хугацаа: “Ам Та Тү” ХХК-ийн ил уурхайн олборлолт, шохойн чулуу шатаан боловсруулах үйлдвэр нь энэ оны эхний хагас жилд үйл ажиллагаа эрхлэхэд шаардлагатай бүх зөвшөөрөл бичиг баримтын бүрдлийг хангаснаар ажил эхэлнэ.

Төслийн ТЭЗҮ-д уурхайн олборлолт, ашиглалтыг 10 жилээр төлөвлөсөн байна. Энэ хүчин чадлаар ажиллахад ордын нөөц нь 64 жил хүрэлцээтэй.

ХОЁР. СӨРӨГ НӨЛӨӨЛЛӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ, БУУРУУЛАХ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

2.1. Төслийн үйл ажиллагаанаас агаарын үзүүлж болзошгүй гол сөрөг нөлөөлөл

Агаарын чанарт дараах хүчин зүйлүүд нөлөөлнө.

- ✓ Хөрс хуулалт, хөрс хуулах, ачих, буулгах болон овоолго хийх үед гарах тоос
- ✓ Тэсэлгээний ажлын үед гарах тоос
- ✓ Хөрс болон шохойн чулуу ачих тээвэрлэх үед гарах тоос
- ✓ Машин, механизмаас гарах утаа, хий
- ✓ Зам барилгын үед гарах тоос
- ✓ Халаалтын зуухнаас үүсэх хий
- ✓ Тээврийн хэрэгслийн хөдөлгөөнөөр үүсэх тоос зэргээс агаарын чанар хамаарна.
- ✓ Орчны агаар бохирдуулах эх үүсвэр нь шохойн чулуу ангилан ялгах технологийн дамжлагын бутлах төхөөрөмжүүд
- ✓ Ажлын байрны орчинд шохойг тээрэмдэж савлах орчинд үүсэх тоосжилт зэрэг байна.

Тус уурхай нь хоногт 1652.233л¹, дизель түлш ашиглахаар тооцсон байна. Зуны дизель түлшний нягт MNS 216:2006 Дизелийн түлш. Техникийн шаардлага стандартад зааснаар 875кг/м³ байна гэсэн үзүүлэлтийг энэ тооцоонд ашиглав.

Нэг тонн дизелийн түлш шатахад 15,91кг хорт бодис ялгардаг байна (Хүснэгт 2)

Хүснэгт 2. Уурхайн техникүүдийн дизель түлшний шаталтаас үүсэх хорт хийн хэмжээ

№	Хорт хийн хэмжээ	Хийг хэмжих нэгж	1 тн дизель түлшний шаталт ²	Хоногт ялгарах хорт хийн хэмжээ	2020 онд ялгарах хорт хий
1	Угаарын хий (CO)	гр	0.1	0.145	23.07907
2	Азотын давхар исэл (NO ₂)	гр	0.04	0.058	9.231628
3	Хүхэрлэг хий (SO ₂)	гр	0.02	0.029	4.615814
4	Хөө	кг	15.5	22.41	3566.91
5	Нүүрстөрөгч	гр	0.03	0.043	6.844138
6	Бензапирен	гр	0.32	0.46	73.21636
	Нийт	кг	15.5	22.4	3536.318

Уурхайд MNS216:2006 стандартын зуны түлшний шаардлагыг хангасан дизель түлш хэрэглэхэд дээр дурдсан хорт хий үүсэх тооцоо гарч байна.

¹ ТЭЗҮ VIII бүлэг 3.2. Түлш, шатах тослох материалын зардал 97-99 хуудас

² Инженер лавлах 5, 2010 он, 578 хуудас

Усан орчинд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөлөл

Унд, ахуйн зориулалтаар 945м^3 , нөхөн сэргээлтийн усалгаанд 4.8 м^3 , зам талбай, уурхайн тоосжилт дарах зорилгоор 402м^3 нийт 1351.8м^3 усыг гүний худгаас авч ашиглана³.

Төслөөс усан орчинд үзүүлэх нөлөөлөл нь:

- ✓ Тухайн төсөл нь 12 сарын хугацаанд харьцангуй бага гүнд газар доорх усны тогтонги түвшинд хүрэлгүй ус ашиглалт явуулах тул газар доорх усны байгалийн горимд нөлөө үзүүлэхгүй байх магадлалтай.
- ✓ Технологийн үйл ажиллагаанд химийн бодис хэрэглэхгүй тул гүний болон гадаргын усны найрлага чанарт нөлөө үзүүлэхгүй ч түлш шатахуун, шатах тослох материалууд, шохой асгарах зэргээс үүдэн газрын болон газрын доорх ус бохирдох эрсдэлтэй.
- ✓ Мөн ахуйн хатуу болон шингэн хог хаягдлын асуудлаа зөв менежментийн дагуу явуулаагүйгээс болж газрын гадарга болон гүний ус биологийн болон химийн бохирдолд орох эрсдэлтэй.

Газар болон газрын гадарга, хэвлийд үзүүлж болзошгүй гол сөрөг нөлөөлөл

Хөрс хуулалт болон уурхайн дэд бүтэц, тосгон болон шохойн чулуу шатаах үйлдвэрийн барилга байгууламж барих, цаашдын ашиглалтын үйл ажиллагаанаас газрын гадаргын төрх байдал алдагдаж, хөрсөн бүрхэвч дарагдах, ухагдах, элэгдэх байдлаар, ургамлан нөмрөг хуулагдах, хөрсөнд дарагдах зэргээр эвдрэлд орно.

Төслийн нутаг дэвсгэр болон түүний эргэн тойрны нутаг дэвсгэр дэх тээврийн хэрэгсэл, хүмүүсийн хөдөлгөөний ихсэлттэй холбоотойгоор хөрсөн бүрхэвч элэгдэн доройтох, ургамлан нөмрөг тоосонд дарагдаж тачир сийрэг болж бүрхэц багасна. Газрын гадарга болон хөрс ахуйн хаягдал, шатах тослох материалаар бохирдох нөлөөлөл бий болж болзошгүй.

Ургамлан нөмрөг, амьтны аймагт үзүүлж болзошгүй гол сөрөг нөлөөлөл

Барилгажилт, дэд бүтэц байгуулах, ил уурхайн үйл ажиллагаагаар хөрс хуулагдах талбайн ургамал нөмрөгт шүүд сөрөг нөлөө үзүүлнэ. Мөн үйл ажиллагаагаар үүсэх тоосжилт нь орчны ургамлын ургалт, өсөлт хөгжилтөд болзошгүй сөрөг нөлөө учруулна.

Төслийн ерөнхий үнэлгээгээр нэн ховор статус бүхий амьтан тодорхойлогдоогүй.

Төслийн үйл ажиллагаанд ашиглагдах техник тоног төхөөрөмжөөс гарах дуу чимээнээс болж хөхтөн, шувуу, жижиг мэрэгч амьтдууд дайжиж алга болох, мөн хөрс хуулалтын үйл ажиллагаанаас хөрсөн дэх макро, микро бичил амьтад үхэж хорогдох зэрэг нөлөөллүүд үүснэ.

³ УАТ-2019 Маягт 6.2. Усан хангамж

ГУРАВ. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Хүснэгт 3. Байгаль орчинд учирч болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал (төгрөг)	Тоо хэмжээ	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
Агаарын чанар									
1.	Тээврийн хэрэгслийн яндангаас утаа болон хорт хий ялгарах	Түлшний чанарын хяналт техникийн хяналт, үзлэг оношилгоог тогтмол тогтоосон хугацаанд хийж байх	Уурхайн бүхий л үйл ажиллагаа	ширхэг	50,000	3	150.0	2024 онд 1 удаа	- Байгаль хамгаалах тухай хууль - Агаарын тухай хууль
2.	Эрүүл ахуйн шаардлага хангах, үнэрийн бохирдол тархахаас сэргийлэх	Хогийн цэгийн ойр орчмыг дулааны улиралд ялаа, шавж, бактери үржих, үнэрийн бохирдол тархахаас урьдчилан сэргийлж ариутгал хийж байх,	Хогийн цэг		25,000	2	50.0		- MNS 5013:2009 Бензинээр ажилладаг хөдөлгүүртэй автомашин Утааны найрлага дахь хорт бодисын зөвшөөрөх дээд хэмжээ
3.	Ил уурхайн ашиглалтын үйл ажиллагааны үед эвдэгдсэн газруудаас салхи ба техникийн нөлөөгөөр тоос үүсэх	Зам талбайн усалгаа	Уурхайн ухаш	-	-	-	Ус ашиглах гэрээнд тусгасан дүнгээр төлбөр төлнө	Гэрээнд заасан хугацаа бүрд	- MNS 5014:2009 Дизель хөдөлгүүртэй автомашин Утааны тортогжилтын зөвшөөрөх дээд хэмжээ ба хэмжих арга
4.	Уурын зуухны утаа болон ялгарах хорт хий	Нүүрсний утааг 40% бууруулах YCT-315-4A загварын зуух суурилуулахаар төлөвлөсөн	Зуух	-	-	-	Дотоод төлөвлөлтөөр	2024 он	- MNS 4585 :2016 Агаарын чанар, Техникийн ерөнхий шаардлага
Хөрсөн бүрхэвч									
1	Шимт хөрсийг технологийн дагуу хуулна	Шимт хөрсийг стандартын шаардлагын дагуу хадгалж, хамгаалах	Шимт хөрсний овоолго	-			Дотоод төлөвлөлтөөр	2024 он	MNS 5916:2008 Газар шорооны ажлын үед үржил шимт хөрс хуулалт, хадгалалт MNS 5859:2008 “Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх хэмжээ”
2	Шатах тослох материал (ШТМ) асгарсан тохиолдолд орчны хөрсөн бүрхэвчийг	Авто засварын талбайг хатуу хучилттай болгох	Засварын газар	-	-		Дотоод төлөвлөлтөөр	2024 он	

АРАЛТ ХУДАГ ШОХОЙН ЧУЛУУНЫ ОРДЫН 2024 БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал (төгрөг)	Тоо хэмжээ	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	бохирдуулж болзошгүй								
3	Төслийн үйл ажиллагааны үед үүссэн тоос шороо ургамал дээр унаж хуримтлагдсанаар ургамлын фото синтез явагдах боломжгүй болж, ургамал ургах чадвараа алдах	Тоосжилт дарах усалгаа хийх	Тоос үүсэх бүх орчин	-	-	Агаарын хэсэгт тусгасан		Тоос үүсэх бүрд	
4	Хөрсний бохирдол, талхагдал	Ажилчдын байр барихад шимт хөрсийг стандартын дагуу хуулах Барилгын материалыг эмх цэгцтэй хураах	Кемп	-		Дотоод төлөвлөлтөөр		2024 онд	MNS 5916:2008 Газар шорооны ажлын үед үржил шимт хөрс хуулалт, хадгалалт
Сөрөг нөлөөг бууруулах нийт зардал						200.0 мян.төг			

ДӨРӨВ. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Техникийн болон биологийн нөхөн сэргээлт

Энэ онд техникийн болон биологийн нөхөн сэргээлтийн ажлууд уурхайлалтад өртөгдөх талбайд хийгдэхгүй, шимт хөрсний овоолго, хадгалалт, уурхайн тосгон орчмын тохижилт нөхөн сэргээлтийн ажлууд хийгдэнэ.

Шимт хөрсний овоолгыг хөрсийг стандартын дагуу хэлбэршүүлэн уурхайн биологийн нөхөн сэргээлтэд зориулан ургамалжуулан хадгална. Мөн уурхайн ажилчдын тосгон орчмыг тохижуулан тарималжуулна.

Мод үржүүлэг, бойжуулсан туршилтын талбай

Төслийн талбай нь ургамал, газарзүйн мужлалаар хээрийн бүсэд харьяалагдах бөгөөд БОННУ-нд дурдсаны дагуу бүс нутагт зохицон ургах чадвартай мод, бут сөөг, тухайн бүс нутгийн унаган олон наст ургамлын зүйлүүдийг тарьж, турших “Уурхайн нөхөн сэргээлтийн туршилтын үе шат”-ыг 2020 онд эхлүүлсэн.



Зураг 2. Туршилтын талбайн харагдах байдал

2024 онд уурхайн тосгоны тохижилтод 30ш мод тарихаар төлөвлөж байна.



Зураг 3. Мод тарьсан талбайн харагдах байдал

АРАЛТ ХУДАГ ШОХОЙН ЧУЛУУНЫ ОРДЫН 2024 БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

2024 онд Тэрбум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд Чойбалсан сумын ЗДТГ-аас өгсөн саналын дагуу 70 ширхэг Агч модыг нөхөн тарилт хийж, мод тарьсан талбайг хашиж хамгаалахаар төлөвлөж байна.


Хүснэгт 4. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө

№	Нөхөн сэргээлтийн зорилт	Нөхөн сэргээлтийн арга хэмжээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал (төгрөг)	Нийт зардал (төгрөг)	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Биологийн нөхөн сэргээлт	Мод үржүүлэг туршилтын талбай байгуулах, тарьц суулгац авах, тухайн орчныг тохижуулж эхлэх	ш	70	11,000	770,000	2024 оны 8-9	MNS 6141:2010, MNS 6138:2010,
2		Мод тар тарьсан талбайг хашаажуулах	метр	-	-	1,900,000	2024 онд	6258-1:2011
3		Уурхайн тосгонд мод тарих	ш	30	11,000	330,000	2024 оны 8 сард	MNS 5918:2008
Нийт зардал мян.төг						3,000,000		

ТАВ. БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

“Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах” гэдэг нь төслийн үйл ажиллагаанд өртөгдөн унаган төрх, хэв шинж, амьдрах орчноо алдсан биологийн олон янз байдлыг өөр газарт нөхөн хамгаалах арга хэмжээг хэлнэ.

Дорнод аймгийн байгаль орчин аялал жуулчлалын газраас гаргасан уриалгын дагуу хүн хүч, техник тоног төхөөрөмж туслалцаа үзүүлэхээр 2,000,000 сая төгрөгийг төсөвлөсөн.



ЗУРГАА. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ ТӨЛӨВЛӨГӨӨ

Энэхүү төслийн үйл ажиллагааны хүрээнд нүүлгэн суурьшуулах ажил хийгдэхгүй.

ДОЛОО. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭ

Уурхайн ашиглалтын талбай орчимд хийгдсэн судалгаагаар ямар нэгэн археологи, палеонтологийн олдвор бүртгэгдээгүй. Гэвч уурхайн газар шорооны ажлын явцад соёл өв олохыг үгүйсгэж болохгүй. Тиймээс уурхай үйл ажиллагааны явцад соёлын өв олдсон тохиолдолд Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 30.4-т заасны дагуу олдворыг илрүүлсэн өдрөөс хойш 30 хоногийн дотор сум, дүүргийн бүртгэл мэдээллийн санд заавал бүртгүүлнэ. Хэрэв уурхай ашиглалтын явцад соёлын өв илэрсэн олдсон тохиолдолд уурхайн үйл ажиллагааг түр зогсоон холбогдох мэргэжлийн байгууллагаар авран хамгаалах малтлага судалгааг хийлгэх нь зүйтэй.

Хүснэгт 5. Түүх, соёлын өвийг хамгаалах менежментийн төлөвлөгөө

№	Нөлөөлд өртөх түүх, соёлын өв	Хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, мян.төг	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	1	2	3	4	5	6	7	8
1.	Төслийн үйл ажиллагаагаар түүх соёлын өвд үзүүлэх шууд сөрөг нөлөө байхгүй ч болзошгүй нөлөөллөөс урьдчилан сэргийлэх шаардлагатай.	Соёлын өвийг хамгаалах тухай МУ-ын хуулийн дагуу газрын хэвлийг ашиглах явцад түүх, соёлын дурсгалт зүйл илэрвэл олборлох ажлаа зогсоож энэ тухай, аймгийн Засаг дарга, цагдаагийн болон уг асуудлыг эрхэлсэн эрдэм шинжилгээний байгууллагад нэн даруй мэдэгдэх	Уурхайн орчим	-	Бүтээн байгуулалт, үйл ажиллагаанд нэмэлтээр тусгах		2024 онд	Соёлын өвийг хамгаалах тухай хууль

НАЙМ. ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Осол эрсдэлээс хамгаалах ажлын ихэнх нь төслийн үйл ажиллагааны явцад хөдөлмөрийн сахилга бат, хариуцлагын тогтолцоогоор шийдвэрлэгдэх боломжтой бөгөөд цаг уурын эрсдэлтэй нөхцөлөөс үүсэх гэнэтийн осол, цаашлаад зэрлэг ан амьтдын ослоос урьдчилан сэргийлэх ажилд холбогдох зардал нь төслийн үйл ажиллагааны зардлын санхүүжилтийн хүрээнд шийдвэрлэгдэх боломжтой юм.

Хүснэгт 6. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө

№	Болзошгүй аюул, осол, сөрөг нөлөө	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1.	Цаг уурын эрсдэлтэй нөхцөлөөс үүсэх гэнэтийн осол	Урьдчилан сэргийлэх мэдээ болон дохиолол холбооны найдвартай байдлуудыг байнга хангах	Төслийн бүх ажилтан, ажиллагсдад хамаарна.	Үйл ажиллагааны зардлаар			2024 онд	
2.	Хөдөлмөрийн сахилга бат алдсанаас үүсэх осол	Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, дотоод хяналт, байгууллагын дотоод дүрэм журам мөрдөж, хариуцлагын тогтолцоог бэхжүүлэх	Бүх шатны ажиллагсдын ажил үүргийн хуваариар тодорхойлогдсон байна.					
3.	Шатахууны агуулахын ашиглалтын үед үүсэж болох эрсдэл							
4.	Галын аюулгүй байдал	Гал түймрээс урьдчилан сэргийлэх тоног төхөөрөмж, багаж хэрэгслийн тодорхой цэгүүдэд байрлуулах	Уурхайн		500.0		2024 оны 6-8 сар	
Осол, эрсдэлийн менежментийг хэрэгжүүлэх нийт, мян.төг								500.0

Тэсэлгээний бодис материалын хэмжээ, үзүүлэлтүүд:

Төслийн үйл ажиллагаанд жилд 1-2 удаа хөрс, чулуулгийн сийрэгжүүлэлтэд тэсэлгээний ажил хийгдэх ба энэ нь тусгай зөвшөөрөлтэй мэргэжлийн байгууллагын удирдлага, хяналт дор хийгдэнэ. Тэсэлгээг 2024 онд “Монмаг” ХХК гүйцэтгэнэ.

Хүснэгт 7. 2024 онд хэрэглэх тэсрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн хэмжээ

№	Зориулалт	Нэр, төрөл	Хэмжих нэгж	Нийт хэрэглээ	Тайлбар
1	Тэсрэх бодис	Анфо	тн	9.8256	Зарцуулалт 0.69кг/м ³ гэж тооцсон
2	Тэсрэх бодис	Эмульс	тн	0.286	Гадаргын уснаас шалтгаалж 286 кг ашиглана гэж төлөвлөсөн
3	Тэсэлгээний хэрэгсэл	Цооногийн нонель	ш	263	
4	Тэсэлгээний хэрэгсэл	ДША шнур	ш	2150	
5	Тэсэлгээний хэрэгсэл	ОШП шнур	м	90	
6	Тэсэлгээний хэрэгсэл	Капсуль кд	м	80	
7	Тэсэлгээний хэрэгсэл	Реле удаашруулагч	ш	263	
8	Тэсэлгээний хэрэгсэл	Өдөөгч	ш	263	

Эдгээр материалуудаас анфо нь 94% аммоний нитрат, 6% дизель түлш агуулсан химийн бодис бол эмульс нь эмульс доторх шатах шингэн нь аммиакийн шүүний усанд ханасан уусмалын жижиг хэсгүүдийг нимгэн үе үүсгэн бүрхсэн уусмалын ба тосон фазын нэгдэл юм (Зураг 4).


Усанд тэсвэртэй тэсрэх бодисын шинэ нэр төрөл, чиглэл нь эмульсийн тэсрэх бодис юм. Энэ нь эмульс доторх шатах шингэн нь аммиакийн шүүний усанд ханасан уусмалын жижиг хэсгүүдийг нимгэн үе үүсгэн бүрхсэн уусмалын ба тосон фазын нэгдэл юм. Энэ тэсрэх бодис нь усанд тэсвэртэй физик тогтонги чанар сайтай, харьцангуй хямд үнэтэй, бэлтгэхэд аюул осолгүй, ямар ч нөхцөлд хэрэглэх боломжтой, тэсрэлтийн шинж чанарын үзүүлэлт өндөр зэрэг давуу сайн талуудтай. Эмульсийн тэсрэх бодисын үндсэн найрлага нь аммиакийн шүүний эмульсийн уусмал, шатах шингэний нэгдэл юм



Зураг 4. Худалдааны анфо, эмульсийн тэсрэх бодисын ерөнхий байдал

Бусад материалууд нь туслах материалд хамаарч байгаа бөгөөд туслах материалуудын ерөнхий байдлыг зураг 3-д үзүүлэв. Үүнээс цооногийн денатор болон бялт тэслүүрийн найрлагад хартугалганы азид, хартугалганы 2, 4, 6-тринитробензен-1,3-диолат гэсэн бодисууд оролцсон байдаг бол удаашруулагч реле, цочир дамжуулах шижим, гал дамжуулах шижим, гадаргуугийн хором нь дамжуулагч хэрэгслүүд юм.

а. Цооногийн детонатор, в. Бялт тэслүүр, с. Удаашруулагч реле, d. цочир дамжуулах шижим, e. Гал дамжуулах шижим болон гадаргуугийн хором



Зураг 5. Тэсрэх материалуудын ерөнхий байдал

“Тэсэлгээний ажлын аюулгүй ажиллагааны нэгдсэн дүрэм”-ийн ерөнхий зүйлийн 18-д зааснаар тэсрэх бодис, тэсэлгээний хэрэгслийг агуулахад тохирох ангиллын дагуу тус тусад нь хадгална.

Тэсэлгээний аюулгүй ажиллагаа:

Хэрэв тэсэлгээний тооцоогоор чичиргээний аюултай үйлчлэх R_r радиусын хэмжээ нь бодит зайн хэмжээнээс давж байвал барилга байгууламжид чичиргээ доргио аюултай нөлөө үзүүлнэ. Иймээс аюулгүйн зайн талаас нь бодож нэг удаагийн тэсэлгээнд хамрагдах тэсрэх бодисын хэмжээг хязгаарлах арга хэмжээ авна. Аюултай бүсүүдийн хилийг тогтоож, тусгай тэмдэг байрлуулах ба тэсэлгээний өмнө харуул хамгаалалт гаргана. Тэсрэх материалыг зөөх, байрлуулах, цооногуудыг цэнэглэх холболтууд хийх зэрэг тэсэлгээний бэлтгэл ажиллагааг дүрэм журмын заалтуудын дагуу хийж гүйцэтгэнэ.

Тэсэлгээнээс өмнө аюултай бүсэд буй тоног төхөөрөмжүүдийг холдуулж аюулгүй бүсэд гаргах цахилгааны шугамыг хүчдэлгүй болгох зэрэг аюулгүйн нөхцөл хангах ажиллагаануудыг хэрэгжүүлнэ. Тэсэлгээг хэвшиж тогтсон өдөр цагт явуулна. Тэсэлгээний аюултай бүсээс хүмүүсийг гаргахын тулд анхааруулах дохио өгдөг. Уурхайнуудад ихэвчлэн дуут дохиог хэрэглэдэг. Зарим уурхайд бага цэнэг тэсэлж дохио өгч хэвшсэн байдаг.

Тэсэлгээг удирдаж буй хүн бэлэн байдлыг хянаж дохио өгсний дараа тэсэлгээчин тэсэлгээг явуулна. Тэсэлгээний дараа тэсэлгээ явагдсан блокт үзлэг хийж гацаа (бааралт) үүссэн эсэхийг тогтооно. Тэсэлгээ хэвийн явагдсан бол дохио өгч тэсэлгээ дууссаныг мэдэгдэнэ. Хэрэв ямар нэгэн гацаа үүссэн байвал түүнийг устгах арга хэмжээ авна.

Тэсэлгээ дууссан дохио өгөгдөөгүй тохиолдолд аюултай бүсэд орох, үйл ажиллагаа явуулахыг зөвшөөрөхгүй. Их хэмжээний тэсрэх бодис хэрэглэсэн буюу эсвэл гүн уурхайн гүний хэсэгт тэсэлгээ хийсэн бол тэсэлгээний дараах агааржуулалт явагдсаны дараа тухайн бүсэд хүн ажиллаж болно. Тэсэлгээ бүрийг хэрэгжүүлсэн тухай баримт үйлдэнэ.

Хүснэгт 8. Тэсэлгээний аюултай бүсийн радиус

№	Үзүүлэлт	Тэмдэг -лэгээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ
1	Тэсэлгээгээр шидэгдэх чулуулаг хүмүүст аюултай үйлчлэх зай	R _{шх}	м	500
2	Тэсэлгээгээр шидэгдэх чулуулаг тоног төхөөрөмжид аюултай үйлчлэх зай	R _{шт}	м	300
3	Агаарын долгионы цохилт хүмүүст аюултай үйлчлэх зай	R _{цх}	м	1500
4	Агаарын долгионы цохилт барилга байгууламжид аюултай үйлчлэх зай	R _{цб}	м	500
5	Чичиргээ доргионы аюултай үйлчлэх зай	R _ч	м	150

Тэсэлгээний ажлын зохион байгуулалт:

Ил уурхайд хийгдэх тэсэлгээ бүрт тусгай паспорт боловсруулж мөрдлөг болгоно. Тэсэлгээний ажлын дүрэм, тухайн уурхайд мөрддөг журмын заалтуудыг хатуу баримталж тэсэлгээний ажлыг зохион байгуулна. Тэсэлгээний ажлын зохион байгуулалтыг дараах ерөнхий дараалал байдлаар ойлгож болно. Үүнд:

- ✓ Тэсэлгээний паспорт зохиож батлуулах
- ✓ Тэсрэх бодис, тэсэлгээний хэрэгслийг зарцуулах зөвшөөрөл авах
- ✓ Цооног цэнэглэх ба түгжээс хийх
- ✓ Тэсрэлтийн аюултай бүсээс хүмүүс болон тоног төхөөрөмжийг гаргах
- ✓ Тэсрэлтийн аюултай бүсэд буй цахилгааны шугамд салгалт хийх
- ✓ Тэсрэлтийн аюултай бүсийн харуул хамгаалалтыг гаргах
- ✓ Тэсэлгээний схемийн холболтуудыг хийж тэсэлгээнд бэлтгэх
- ✓ Тэсэлгээний схемийн бэлэн байдлыг шалгах
- ✓ Тэсэлгээ явуулах тухай дохио өгөх
- ✓ Тэсэлгээг хийх
- ✓ Тэсэлгээний хяналтын үзлэг хийх ба тэсэлгээ хэвийн явагдсан бол тэсэлгээний ажил дууссан тухай дохио өгөх. Хэрэв зарим цооногийн цэнэгүүд баарч тэсрээгүй бол тэдгээрийг тэсэлж аюулгүй болгох арга хэмжээ авах ба дараа нь тэсэлгээний ажил дууссан тухай дохио өгөх
- ✓ Тэслэгдсэн чулуулгийн холбогдолтой хяналтын хэмжилт, тооцоог хийж дүгнэлт гарган тухайн тэсэлгээний ажлыг дуусгасан тухай баримт бичгийг бүрдүүлэх.

2024 онд 1 удаа тэсэлгээ хийхэд ашиглагдах тэсэлгээний бодис, туслах материал хэрэгслийн сав баглаа боодол, үлдэгдэл, шаардлага хангахгүй болсон тэсрэх материал, түүний хэрэгслүүдийг гэрээгээр ажил үйлчилгээ эрхэлж буй тусгай зөвшөөрөлтэй мэргэжлийн байгууллага нь зохих журмын дагуу зайлуулах, устгах үүрэг хүлээнэ. Хатуу хог хаягдлаас дахин ашиглах боломжтойг нь хоёрдогч түүхий эд авах цэгт нийлүүлэх, тэсрэх бодис болон материалын хаягдлыг Засгийн газрын 2006 оны 149 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралтаар батлагдсан ТЭСЭЛГЭЭНИЙ АЖЛЫН АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААНЫ НЭГДСЭН ДҮРЭМ-ийн 87-103-т заасан аргачлалаар устгана.

ЕС. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Хүснэгт 9. Хог хаягдлын менежмент

№	Хог хаягдлын ангилал	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, төг	Тоо хэмжээ	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1.	Ахуйн	- ангилсан хог түр хадгалах цэг тохижуулах	Төслийн ажилчдын кемп, үйлчилгээний зал, нийтийн эзэмшлийн талбай, ариун цэврийн өрөөнүүд	тн	50,000	30	500.0	7 хоногт 1 удаа	“Хог хаягдлын тухай” хууль, “Энгийн хог хаягдлыг ангилах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах, булшлах үйл ажиллагаанд тавигдах ерөнхий шаардлага”, “Хог хаягдлын улсын мэдээллийн нэгдсэн сангийн тогтолцоо, бүрдэл болон мэдээлэл төвлөрүүлэх журам”
2.	Үйлдвэрийн	- Мэдээлэл сурталчилгаа хийх, тэмдэгжүүлэх		-	-	-	-	-	
3.	Аюултай	- Хаягдал зайлуулах гэрээг эрх бүхий этгээдтэй хийх	Аюултай хог хаягдал үүсэх эх үүсвэрүүд	тн	100,000	4	400.0	Улиралд 1 удаа	
4	Түр хадгалах	Хог хаягдлыг ангилан ялгах, түр хадгалах төвлөрсөн цэгийг битүүмжлэн байгуулах	Уурхайн хэмжээнд	шир	Дотоод төлөвлөлтөөр		2024 он		
Хог хаягдлын менежментийг хэрэгжүүлэх нийт зардал, мян.төг									900.0

Хог хаягдлын менежментийн цар хүрээ

Баримтлах зарчим. Уурхайн үйл ажиллагааны явцад “Хог хаягдлын менежмент”-боловсруулах нь хэрэгжүүлэх бөгөөд энэ нь дараах зарчмыг баримтална.

Үүнд:

- Хог хаягдлын тухай Үндэсний болон Олон Улсын нийтлэг хууль, журмыг дагаж мөрдөхөд нийцсэн орчин бүрдүүлнэ.
- Хог хаягдлын менежментийн хүрээнд байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас болон 2019 оны 5 сарын 07-ны өдрийн “Хог хаягдлын менежмент” Үндэсний чуулганаас гаргасан зөвлөмжийг дагаж мөрдөнө.

Хог хаягдлыг ангилах. Уурхайн үйл ажиллагаанаас дараах төрлийн хог хаягдлууд гардаг бөгөөд одоогийн байдлаар “Хог хаягдлын менежмент”-ийн зураг авалт хийж тоо хэмжээг тодорхойлсон зүйлгүй байна. Уурхайн үйл ажиллагаанаас гарах хаягдлыг дараах эрэмбээр ангилна.



Зураг 6. Хог хаягдлын аюулын зэрэглэл, ангилал

Хог хаягдлыг түр хадгалах. Уурхайн үйл ажиллагаанаас үүсэх хог хаягдлыг ангилах, өөр дээр түр хадгалахад “Хог хаягдлын тухай” хуульд заасан шаардлагад нийцүүлэх бөгөөд хуулийн 7 дугаар бүлгийн 14 дүгээр зүйлд заасан “Энгийн хог хаягдлыг цэвэрлэх, цуглуулах, тээвэрлэх” болон Засгийн газрын 2018 оны 116 тоот тогтоол, “Аюултай хог хаягдлыг түр хадгалах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, устгах болон бүртгэх, тайлагнах журам”-ын хүрээнд хэрэгжүүлнэ.

Хог хаягдлын менежментийг хэрэгжүүлэх

Хог хаягдлын хэмжээг тодорхойлох. Төслийн үйл ажиллагаанаас хоногт дунджаар 96 кг орчим хог гарна гэж БОННУ-ний “Төслийн товч тодорхойлолт” хэсэгт өгүүлсэн байна. Ажлын зураг авалтаас шалтгаалан шаардлагатай гэж үзвэл зарим цэгүүдэд нэг төрлийн ангиллын савыг хэд хэдээр зэрэгцүүлэн тавьж болно.



Зураг 7. Хаягдал цуглуулах сав

Хог хаягдлыг зайлуулах. Уурхайн үйл ажиллагаанаас хог хаягдлыг зайлуулахад ангилсан нэр төрөл бүрээр холбогдох арга хэмжээг хэрэгжүүлэхийн тулд хог хаягдал хүлээн авах хоёрдогч зах зээлд болон дахин боловсруулагчид, устгал хийх эрх бүхий этгээдүүдтэй тус бүрчлэн гэрээ хийнэ. Энэ ажлыг төслийн үйл ажиллагаа эхлэхэд хамт хэрэгжүүлж эхлэнэ.

Хог хаягдлын ангилал. Уурхайн үйл ажиллагаанаас гарах хог хаягдлыг дээр заасан байдлаар ангилах бөгөөд тэдгээрт нийцсэн арга хэмжээг хэрэгжүүлж уурхайн орчинд хог хаягдлыг ангилах, ангилсан хог хаягдлыг төвөг багатайгаар цуглуулах тухай мэдээллийг үйлчлүүлэгч олон нийтэд мэдээлж

сурталчлахын зэрэгцээ хогийн цэгүүдийг оновчтой байршуулж холбогдох тэмдэг, тэмдэглэгээг ойлгомжтойгоор хийнэ.

Хүснэгт 10. Төслийн үйл ажиллагаанаас үүсэх хог хаягдлын ангилал

№	Менежментийн ангилал	Уурхайд үүсэх хог хаягдал	Хог хаягдлыг зайлуулах
1	Дахивар хаягдал	хүнсний болон бүх төрлийн шилэн сав, шилэн эдлэл	Дахивар хог хаягдал хүлээн авагчидтай гэрээ хийж хоёрдогч зах зээлд нийлүүлнэ. Гэрээнд ангилсан хог хаягдлын шаардлагад хэрхэн нийцүүлэх тухай асуудлыг тусгана.
		Хөнгөн цагаан, төмөр, метал, зэс, гууль, тэдгээрээр хийсэн зүйл	
		Элдэв зөөлөн хуванцар, гялгар уут, гялгар баглаа боодол	
		Хувцас, даавуун эдлэл	
		Савхи, резин, мод зэрэг дахин ашиглах боломжит бусад хаягдал	
2	Цаасны хаягдал	сонин, сэтгүүл, дэвтэр	
		бичгийн цаас	
		төрөл бүрийн боодлын цаас, картон	
		сүү, жүүсний тетрапак савлагаа	
3	Хүнсний хаягдал	Нийтийн хоолны үлдэгдэл	Хог хаягдлыг устгах сумын нэгдсэн цэгт нийлүүлэх гэрээ хийж ачилтын хуваарийг тохирно.
		Хүнсний ногоо, жимсний хальс, үлдэгдэл	
		Хэрэглэсэн хүнсний тос	
4	Аюултай хаягдал	ШТМ-ын сав, нөөцлүүр, тоног төхөөрөмжийн цэвэрлэгээнээс гарсан арчуур, хаягдал тосны үлдэгдэл	Хог хаягдлын тухай хуулийн 8-р зүйлийн 8.4.3-т заасны дагуу харьяа нутаг дэвсгэрийн эрх бүхий аж ахуй нэгжтэй гэрээгээр зайлуулна.
		Принтерийн хор, батарей, аккумулятор зэрэг ашиглалтаас хаягдаж буй техникийн аюултай хаягдал	
5	Бусад хаягдал	Хэт бохирдсон дахин ашиглах боломжгүй хог хаягдалд: <ul style="list-style-type: none"> Нийтийн ариун цэврийн өрөөний хаягдал Нүхэн жорлон Уурхайн үйлчилгээний шингэн хаягдал Мөн ангилаагүй норсон, хэт бохирдсон хаягдлууд орно. 	Шингэн хаягдлыг эрх бүхий этгээдтэй гэрээлсний үндсэн дээр соруулж, ангилаагүй бохир хаягдлыг уурхайн хогийн цэгээс Аймгийн нэгдсэн цэг рүү ачуулж зайлуулна. Нүхэн жорлонг ариутгал, устгал хийсний дараа тэнд нь булшилна.
		Барилгын болон тусгаарлах материалаас гарсан дахин ашиглах боломжгүй хог хаягдал; <ul style="list-style-type: none"> бохирдсон хөрс, шороо, чулуу, элс, хайрга; Бохир усны хүдгийн лав, хагшаас 	Барилгын ажлын үед гарах хог хаягдлыг гүйцэтгэгч компани хариуцан зайлуулах ажлыг гүйцэтгэнэ.
		Дахин ашиглах боломжтой хог хаягдлын ангилалд ороогүй бусад зөвшөөрөгдсөн хог хаягдал	
		Хийн хаягдал: <ul style="list-style-type: none"> Хадгалах түлшний ууршилт Машины ашиглалтаас үүсэх хий 	ШТМ-тай холбогдох шаардлагуудыг тавьж аюулгүй ажиллагааг хангана.

Хог хаягдлыг зайлуулах хүртэл түр хадгалах нөхцөлийг сайжруулах: Уурхайн үйл ажиллагаанаас гарч байгаа хог хаягдлыг дараах эрэмбээр түр хадгална. Үүнд:

- Үүссэн хог хаягдлыг “Уурхайн хогийн төвлөрсөн цэг”-т хүртэл эх үүсвэр дээр нь цуглуулж маш богино хугацаагаар хадгална. Эх үүсвэр хаягдал цуглуулах ажиллагаа нь нийтийн үйлчилгээний үед хаягдлыг ангилсан хэлбэрээр цуглуулах нөхцөлд нийцсэн байна.

- Хог хаягдлыг “Уурхайн хогийн төвлөрсөн цэг” нь ангилсан байдлаар түр хадгалах бөгөөд тэдгээрийг эрх бүхий этгээдэд шилжүүлэх хүртэл хадгална.
- Түр хугацаагаар хадгалах “Уурхайн хогийн төвлөрсөн цэг” нь элдэв үнэр гаргахгүй, хог хаягдлыг норгохгүй, хийсгэхгүй байх нөхцөлийг бүрдүүлсэн байна.

Хүснэгт 11. Хог хаягдлыг цуглуулах, түр хадгалах нөхцөлийг сайжруулах

Нөхцөл	Шаардлага
<p>Эх үүсвэр дээр нь хог хаягдлыг ангилах</p>	<ul style="list-style-type: none"> • Нийтийн үйлчилгээний зам талбайд хог хаягдлыг цэвэрлэж цуглуулахад ангилах боломжит нөхцөлийг бүрдүүлэхэд хог хаягдлын ангиллын олон улсын нийтлэг жишгийг дагана. • Дахин ашиглахгүй бохир хаягдал, хүнсний хаягдлын түр хадгалалт хугацаа болон эргэлтийн хугацааг хамгийн богино байх шийдлийг боловсруулна. • Нүхэн жорлонг байлгах шаардлагатай бол MNS 5924:2015 “Нүхэн жорлон угаадасны нүх. Техникийн шаардлага”-ын стандартад нийцүүлэн шинэчилнэ. • Аюултай хог хаягдлыг цуглуулах, түр хадгалах, зайлуулах менежментийг тусгайлан боловсруулна. • Ангилсан хог хаягдлыг дахин боловсруулах, устгах, эргэлтэд оруулах нөхцөлөөр нь ялган тус тусахад нь “эрх бүхий этгээд”-д гэрээний үндсэн дээр шилжүүлэн өгнө.
<p>Цуглуулсан хог хаягдлыг зайлуулах</p>	<ul style="list-style-type: none"> • Уурхайн орчинд элдэв амьтан цуглах, идэш хайх нөхцөлийг бүрэн хааж хог хаягдлыг ил задгай байдлаар хадгалахгүй байх болно. • Нийтийн үйлчилгээний зам талбай ажилчид нарт хог хаягдлын менежментийн шаардлага тавьж, тэдгээрийн орчинд үүссэн хог хаягдлыг “Уухайн төвлөрсөн хогийн цэгт-” хүлээн авна. • Ажлын байрны хог хаягдлыг эх үүсвэр дээр ангилах нөхцөлийг бүрдүүлж ажиллагсад “Хог хаягдлын менежмент”-ийг таниулан, ангилсан хог хаягдлыг цэгүүдийн байршлыг зааж, тэмдэгжүүлнэ. • Ангилсан хаягдал бүрийг тусгайлан түр хадгалахад эрх бүхий этгээдэд шилжүүлэх хүртэлх эргэлтийн циклийг тооцно. • Хог хаягдлыг цэвэрлэх, цуглуулах, түр хадгалах, зайлуулах явцад ажлын зураг авалт хийж ангилсан нэр төрөл бүрээр тоо хэмжээг тодорхойлно. • Ил задгай хаягдаж байгаа цэгүүдийн байршлыг хугацаа алдахгүй тогтоож шаардлагатай сав бэлдэх, байршуулах, тэмдэгжүүлэх зэрэг арга хэмжээг хурдан шуурхай авна.
<p>Хог хаягдлын боловсролыг дэмжих</p>	<ul style="list-style-type: none"> • Нийтийн үйлчилгээний цэгээс хог хаягдлыг ангилсан хэлбэрээр цуглуулахад тэмдэгжүүлэлт, мэдээлэл, зар сурталчилгааг оновчтой зөв хэрэглэнэ. • Ил задгай хог хаягдал хаях явдлыг бууруулахад чиглэсэн торгууль шийтгэл оногдуулах, мэдээлэл хүлээн авах, урамшууллын систем бүхий олон нийт рүү чиглэсэн арга хэмжээг хэрэгжүүлнэ. • Хог хаягдлын менежментийг хэрэгжүүлэхэд ажиглан-туслах, хянан-шаардах арга хэмжээг хэрэгжүүлэх үүргийг холбогдох ажилтанд давхар үүрэгжүүлнэ. • Шаардлагатай гэж үзвэл нийтийн үйлчилгээний заал, танхимд ажиглан-туслах, хянан-шаардах арга хэмжээг хэрэгжүүлэх сургагч, ажилтанг тодорхой хугацаагаар ажиллуулна.


АРАВ. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР

Хүснэгт 12. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

Бүрэлдэхүүн	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Байршил, координат	Хугацаа давтамж	Нэгжийн өртөг, мян.төг	Нийт зардал төг/жил	Зөвшөөрөгдөх дээд хэмжээ баримтлах стандарт
Усан орчин	Усан орчин рН, цахилгаан дамжуулах чадвар нүүрстөрөгчийн исэл CO ₂ , хүчил HCO ₃ , кальци Ca, хлор Cl, кали K, магни Mg, сод Na, хүхэр S, хүнцэл Ag, бор B, бари Ва, кадми Cd, кобальт Со, хром Сг, зэс Си, төмөр Ре, мөнгөн үс Нg, манган Мп, молебдин Мо, ванади V, цинк Zn, хөнгөн цагаан Al, мөнгө Ag, Хими бактериологийн бүрэн шинжилгээ.	1. Гүний худаг (Өөрийн эзэмшлийн) N48°40'15.96" E114°47'22.64" 2. Гүний худаг N48°41'0.5" E114°48'57.6"	Улиралд 2 удаа	Усны ерөнхий химийн шинжилгээ 41,800 төгрөг Усны 11 элемент хүнд металлын шинжилгээ 38500 төгрөг хими “Инженер геодези” ХХК бактериологи бүрэн шинжилгээний үнэ 78000төгрөг “Монгол ус” ТӨҮГ	158300 * 2 = 316 600	Усан орчны чанарын үзүүлэлт. Ерөнхий шаардлага. MNS 4586:1998 Газрын доорх усыг бохирдуулагч бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ. MNS 6148:2010 Газрын доорх усыг бохирдохоос хамгаалах ерөнхий шаардлага. MNS 3342:1982 Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ. MNS 0900:2018 MNS (ISO) Хүрээлэн буй орчинд нийлүүлэх цэвэршүүлсэн бохир ус. Ерөнхий шаардлага. MNS 4943:2011
Хөрсөн бүрхэвч	Хөрсний механик бүрэлдэхүүн ялзмаг, кадми Cd, кальци Ca, Зэс Cu, хүнцэл As, Мөнгөн үс Нg, Кобальт Со, Никель Ni, хар тугалга Pb, сод Na, магни Mg, төмөр Fe, цинк Zn, сульфат SO ₄ , хүчил саармагжуулах чадвар, хүчил үүсгэх чадвар, ANP/AGP, чулуулгийн найрлага ABA, нийт сульфит Total Sulfur, ялгардаггүй сульфат S N-Ex, пиритийн сульфит P- Sulfur, рН	1. Төслийн талбайн зүүн хойно (фон) N48°40'21.12" E114°48'05.63" 2. Талбайн баруун урд шохой шатаах үйлдвэрийн талбайд N48°40'02.43" E114°47'30.32" 3. Талбайн баруун талд ажилчдын байр орчим N48°40'15.08" E114°47'45.01" 4. Талбайн зүүн талд N48°39'59.94" E114°48'36.31"	Улиралд 2 удаа	Хөрсний механик бүрэлдэхүүн, ялзмаг 22,000төг Хөрсний хүнд металлын шинжилгээний үнэ 11 элемент 36,300 төг “Инженер геодези” ХХК	58300 * 4 =233200	Хөрсний чанар. Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ. MNS 5850:2008

АРАЛТ ХУДАГ ШОХОЙН ЧУЛУУНЫ ОРДЫН 2024 БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Агаарын чанар	Тоосжилт (PM10, PSM, PM25) Гадаад болон дотоод орчны дуу чимээ, доргио, чичиргээ Ажлын байрны эрүүл ахуйн үзүүлэлтүүд (тоос дуу чимээ гэрэлтүүлэг, чийгшил, болон физик бохирдлын түвшин) Бохирдлын цэгэн эх үүсвэр (O2, SO2, NO2, CO)	1. Төслийн талбайн зүүн хойно (фон) N48°40'21.12" E114°48'05.63" 2. Талбайн баруун урд шохой шатаах үйлдвэрийн талбайд N48°40'02.43" E114°47'30.32" (Хөрсний мониторингийн цэгийн ойролцоо сонгов)	Улиралд 2 удаа	SO ₂ , NO ₂ , CO тоосонцор, дуу чимээ БОАЖ сайдын 2011 оны 10 сарын 10-ны өдрийн А-342 дугаар тушаалын хавсралтаар үнийг тооцов	48000 * 2 = 96 000 Техникчийн томилолт 15000	Агаарын чанар. MNS 4585:2016 Агаарт байх бохирдуулах бодисын хүлцэх хэм хэмжээ 5885:2008 Хот суурин газрын агаарын чанарыг хянах журам MNS 17.2.3.16-88 Тоосны хэмжээг тодорхойлох жингийн арга. MNS 4048:88
Ургамал нөмрөг, амьтны аймаг	Хяналт шинжилгээ хийх, талбайн хүрээ, хяналт үнэлгээгээр тодорхойлох үр дүнг тухай бүрд нь тодорхойлно	1км ² талбайн цагаан зээрийн нягтшил 1м ² ургамлын биомасс	Жилд 1 удаа		Дотоод үйл ажиллагаа	Тухайн төслийн талбай болон орчных нь байгалийн унаган төрхөөрөө байгаа экосистемтэй харьцуулах аргаар тодорхойлох
Ажиллагсдын эрүүл мэндийн хяналт үнэлгээ	Мэргэжлийн өвчин судлалын үндэсний төвтэй гэрээ байгуулж ажиллана.		Жил бүр		Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний зардалд тусгагдсан	Ажлын байрны нөхцөл, эрүүл ахуй, хөдөлмөрийн нөхцөл болон аюулгүй ажиллагааны талаар баримталдаг Монгол улсын стандартууд
Нийт дүн						660 800 төгрөг



Зураг 8. Орчны хяналт шинжилгээний цэгүүд

АРВАН НЭГ. УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

Үйл ажиллагаандаа технологийн сахилга батыг чанд баримталж, аваар осолгүй ажиллах талаар байнга анхаарал тавихыг уурхайн дарга хариуцан ажиллана. Доорх ажлуудыг компанийн захирал тушаал гаргаж баталгаажуулна.

Хүснэгт 13. Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө

№	Төлөвлөсөн арга хэмжээ	Урьдчилан тооцсон төсөв	Хэрэгжүүлэх хувиарь				Хариуцсан албан тушаалтан	тайлбар
			2024 он					
			I улирал	II улирал	III улирал	IV улирал		
1	Байгаль орчны болон хөдөлмөрийн аюулгүй байдлын харилцааг зохицуулах дотоод дүрэм, журамтай болох	250		+			Ам та тү ХХК	Байгаль орчныг хамгаалах тухай" хуулийн 10 ¹ -р зүйл
2	Байгаль орчныг хамгаалах, үйлдвэрлэлийн осол, гал түймэр, усны аюул мэтийн гэнэтийн ослоос урьдчилан сэргийлэх, осол гарсан тохиолдолд шуурхай хэрэгжүүлэх арга хэмжээг зохион байгуулах талаар 1 жилд 2 удаа сургалт сурталчилгааны ажлыг мэргэжлийн байгууллага хүмүүстэй хамтран зохион байгуулна.	250	+	+	+			
3	Төслийн үйл ажиллагааны хэрэгжилтэд байгаль орчны төлөвлөгөөт аудитыг хийлгэх	Дотоод төлөвлөлтөөр			+			
4	Галын дүгнэлт гаргуулах	Дотоод төлөвлөлтөөр			+			
5	Тэр бум мод үндэсний хөдөлгөөнд Чойбалсан сумын ЗДТГ-тай хамтран нөхөн тарилт болон хашаажуулах	Дотоод төлөвлөлтөөр			+	+		Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2021 оны 10 дугаар сарын 04-ны өдрийн 58 дугаар зарлиг
6	Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 10 ¹ зүйлийн дагуу байгаль орчны аудитыг хийлгэх	Гэрээгээр үнэ тохирч хийлгэнэ		+	+			Байгаль орчны аудит хийх ерөнхий аргачлал /БОАЖС-ын 2019 оны А/809 дүгээр тушаалын 2 дугаар хавсралт/
7	Хэрлэн голын сав газрын захиргаатай хамтран Усны өдрийг зохион байгуулах хамтран ажиллах	-		+				Усны тухай хууль 28.4, хамтран ажиллах гэрээний 2.11, 2.12 дахь заалт
	Нийт	500.0						

АРВАН ХОЁР. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ НӨЛӨӨЛӨЛД ӨРТӨГЧ ОРШИН СУУГЧИД, ОРОЛЦОГЧ ТАЛУУДАД ТАЙЛАГНАХ ХУВААРЬ

Хүснэгт 14. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг тайлагнах хуваарь, зардал

№	Зардлын агуулга	Тайлагнах хэлбэр	Мэдээллийн агуулга	Зохион байгуулах хугацааны тов	Хариуцах албан тушаалтан	Холбогдох зардал	Зохион байгуулах газар
1	“Ам Та ТҮ” ХХК-ийн холбогдох удирдлага,	Цахим тайлан	Төлөвлөгөөт ажлын тайлан, биелэлтийн үр дүн, дараа жилийн БОМТ	Жил бүрийн 10 сарын 15-ны дотор	“Ам Та ТҮ” ХХК	Үйл ажиллагааны зардлаар	“Ам Та ТҮ” ХХК-ийн байр
2	Аймгийн байгаль орчны газар	Хэвлэмэл болон цахим тайлан		Жил бүрийн 11 сарын 01-ний дотор	“Ам Та ТҮ” ХХК		Нутгийн удирдлагын ордон
3	Орон нутгийн удирдлага, хөндлөнгийн хяналт, харьяаллын багийн ИНХ, уурхай орчмын оршин суугчид	Мэдээллийн илтгэл, хэвлэмэл танилцуулга		Жил бүрийн 10 сарын 01-ны дотор			
БОМТ-г тайлагнах ажлын зардлын дүн, мян.төг							-

ТАВ. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН 2024 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ НЭГДСЭН ТӨСӨВ

Д/д	Зардлын утга	Нийт зардал, төг
1	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	200,000
2	Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө	3,000,000
3	Дүйцүүлэн хамгааллыг хэрэгжүүлэх зардал	2,000,000
4	Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	500,000
5	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	900,000
6	Удирдлага зохион байгуулалтын ажлын зардал	500,000
7	ОХШХ-ийг хэрэгжүүлэх зардал	660,800
8	Нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах хуваарь	-
Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нийт зардлын дүн		7,760,800

2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд нийт **7,760,800** төгрөг зарцуулахаар төлөвлөөд байна.